

## 2010 ОНД ӨЛГИЙЧҮҮДИЙН ТАЛАРХЛЫГ ХҮЛЭЭЖ, УРМЫГ СЭРГЭЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Баян-Өлгийчүүд 2010 онд төрөлх аймгийнхаа 70 жилийн ой угтаж төр, Засаг, УИХ-ын гишүүд, ард иргэдийнхээ дэмжлэгтэйгээр 70 бүтээлч ажил хийх зорилт дэвшүүлэн бүрэн хэрэгжүүлж шинэ ондоо улам ихийг бүтээхээр урам зоригтой хөдөлмөрлөж байна.

2010 оны аймгийн нийгэм, эдийн засгийн бүх үзүүлэлтүүд урьд оныхоос 1,9-50,1 пунктээр дээшлэв.

### 1. Түүхэнд байгаагүй хөрөнгө оруулалт

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтанд зориулан улс, аймаг, нутгийн төсвөөс болон олон улсын байгууллага, үндэсний хэмжээний төсөл, хөтөлбөрийн нэгжүүдээс 16,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь аймгийн түүхэнд байгаагүй үзүүлэлт юм.



## 2. Дэд бүтцийн хөгжилд дэвшил гарав

Өлгий хотын дулааны болон цахилгаан хангамжийн шинэчлэлийн ажил дуусч, дулаан цахилгаан эрчим хүчний доголдолгүй ажиллах боломж бүрдлээ.

2011 оны эхний хагаст багтааж Булган сумын төвийг ЦДАШ-д холбох ажил дуусах бөгөөд ингэснээр бүх сумын төв, тосгон, томоохон багийн төвүүдээ цахилгааны найдвартай эх үүсвэрт холбох зорилт бүрэн биелэгдэнэ.


Алтай, Булган, Дэлүүн, Ногооннуур суманд модон гүүр, Сагсай, Улаанхус суманд томоохон бетон гүүрүүд баригдаж орон нутгийн зам харилцаанд байнга тохиолддог байсан саад бэрхшээлийг арилгав.

Баруун бүсэд томоохонд орох 11,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нисэх буудлын хатуу хучилттай зурвасын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрч 2011 оны 9-р сард ашиглалтад авах боломжтой болсны дээр Өлгий-Цагааннуурын хатуу хучилттай автозамд 6,0 тэрбум төгрөгийн ажил хийгдэж, ашиглалтад орох хугацаа наашлав.

Баруун бүсийн автозамыг хөгжүүлэх төслийн хүрээнд Өлгий-Хашаатын чиглэлийн хатуу хучилттай замыг БНХАУ-ын 50,0 сая ам долларын хөнгөлөлттэй зээлээр 2011 оны эхний хагасаас эхлэн барихаар эцэслэн шийдвэрлэв.



### 3. Өлгий хотын өнгө төрх сайжрав



Аймаг байгуулагдсаны 70 жилийн ойг угтсан ажлын хүрээнд Өлгий хотод 8,4 тэрбум төгрөгийн засвар тохижилтын ажил хийгдэв. Үүний дотор Өлгий хот дахь радио өргөн нэвтрүүлгийн дахин дэмжуулах станцын Монгол улсын хамгийн өндөр цамхаг /антенн/-ийг лазерийн гэрлээр чимэглэж, зар сурталчилгаа байрлуулдаг болов. Мөн Өлгий хотын гудамжуудыг бүхэлд нь гэрэлтүүлэгтэй болгож ХД театрын дэргэд бүргэдийн хөшөө бүхий амралт, зугаалгын талбай байгуулав. Өлгий хотод мод үржүүлгийн газар байгуулж, гудамж талбайд 10000 ширхэг мод тарив.

Мөн Өлгий хотын доторх автозамд 2,9 тэрбум төгрөгийн засвар шинэчлэлийн ажил хийснээр үлдсэн автозамыг 2011 онд шийдвэрлэсэнээр нийт зам талбайг бүрэн шинэчлэх боломжтой болно.


### 4. Эрүүл мэндийн үйлчилгээ иргэдэд ойртов

2010 онд эрүүл мэндийн салбарт өмнөх оныхоос 3 дахин их буюу 2,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулснаар Алтай, Баяннуур, Булган, Ногооннуур сумдад хүн эмнэлгийн шинэ байр барив.

Ингэснээр тус аймгийн 7 сум тус бүр 15-20 ортой орчин үеийн шинэ байртай болж, 2011 онд үлдэж буй 4 суманд шинээр эмнэлгийн байр барих асуудлыг шийдвэрлэсэнээр бүх сумдыг хүн эмнэлгийн шинэ байртай болгох боломж бүрдэнэ. Энэ онд төв, хөдөөгийн эмнэлгүүдэд түргэн тусламжийн туулах чадвар сайтай 9 автомашин, 26 багийн эмч нарт мотоцикл олгогдож, 300-гаад сая төгрөгний эмчилгээний тоног төхөөрөмж нийлүүлэв.

Аймгийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар Улаанбаатар хот дахь ЭНЭШ төв, улсын Клиникийн 3-р эмнэлэг, хавдар судлалын үндэсний төвтэй алсын зайн оношлогоо, сургалтын сүлжээнд холбогдов.





Ийнхүү эрүүл мэндийн үйлчилгээ иргэдэд ойртож чанар нь сайжрав. Энэ бүхний үр дүнд 2010 онд 0-1 насны нялхасын эндэгдэл өмнөх оныхоос 20,6 промиллээр, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 8,9 промиллээр, эхийн эндэгдэл 44,7 промиллээр тус тус буурч, сүрьеэ зэрэг халдварт өвчний гаралт багассан эерэг үзүүлэлт сүүлийн жилүүдэд анх удаа гарч байна.

### **5. Тамирчдын амжилт ахив**

2010 онд манай аймгийн залуучууд тив, олон улсын болон улсын чанартай тэмцээнүүдээс уулын авиралт, сур харваа, бокс, шатар зэрэг төрлөөр 19 алт, 18 мөнгө, 11 хүрэл медаль хүртэж, олон улсын хэмжээний мастер нэг, спортын мастер 5, дэд мастер 13 төрөн гарсан нь өнгөрсөн оныхоос хэд дахин олон байна.

Энэ онд 2,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 850 суудалтай биеийн тамир спортын орчин үеийн цогцолборыг ашиглалтанд хүлээн авлаа. Энэ цогцолбор манай аймгийн биеийн тамир спортын хөгжилд түүхэн үүрэг гүйцэтгэнэ гэж иргэд олон нийтээрээ талархаж байна.



### **6. Боловсролын салбарт ч бас ахиц гарав**

Баян-Өлгий аймгийн Казах сургуулийн боловсролыг дэмжиж Засгийн газрын тогтоол гарч, олон жил яригдсан казах сурганы сектор байгуулагдах асуудал болон Өлгий сумын 1-р Ахлах сургуулийг шинээр барихад 2,5 тэрбум төгрөг, мөн 100 хүүхдийн цэцэрлэг барих өрөнгө шийдвэрлэгдэлээ. Улсын хэмжээнд тус аймаг

боловсролын үзүүлэлтүүдээрээ Улсын хэмжээнд олон жилийн турш сүүлийн буюу 21 дүгээр байранд байсан бол 2010 онд 17 дугаар байранд орж ахиц гарав.

### **7. Соёл, уламжлалаараа бахархав**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэг, тус аймаг дахь Монголын бүргэдчдийн холбооны санаачлагаар Казахстанын бүргэдийн ан, шувуучлахуйн өв уламжлалыг Монгол улс НҮБ-ын ЮНЕСКО биет бус соёлын өвөөр бүртгүүлэв.

Тус аймгийн ЕБС-ийн сурагчид Казахстан улсад зохиогдсон Олон улсын казах хэл, уран зохиолын олимпиадад түрүүлж, хэл, соёлоо унаган төрхөөр нь хадгалан үлдсэнээрээ гайхуулав. Уг олимпиадад казах үндэстэн оршин амьдардаг 15 орны сурагчид оролцсон байна.

Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч Т.Султаны “Хэлмэгдэгсэд” түүхэн жүжгийг аймгийн ХД театрын тайзнаа амилуулж үзэгчдийн талархлыг хүлээв.



### **8. Ажлын байр нэмэгдэв**

2010 онд аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогчдыг бүх талаар дэмжин ажилласнаар шинээр 1620 ажлын байр буй болгов. Сүүлийн хоёр жилд 198 иргэн, аж ахуйн нэгжид 1.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 51 жижиг үйлдвэр байгуулагдав.

### **9. Байгалийн гамшиг зудыг хохирол багатай даван туулав**

Аймгийн засаг захиргааны байгууллага, нийт ард иргэдийн хүчин чармайлт, төр, засаг, гадаад, дотоодын түншүүдийн дэмжлэг туслалцааны ачаар малчдад 780,0 гаруй сая төгрөгийн тусламж үзүүлж, 2009-2010 оны өвөл, хаврын байгалийн гамшиг зудыг хамгийн бага хохиролтойгоор даван туулж, 2010-2011 оны өвөлжилтийн бэлтгэлээ сайн хангав.

**10. Газар тариаланд ахиц гарав**

Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, айл өрх, өргэдийн тоо эрс нэмэгдэж аймгийн хэрэгцээт төмсний 87 хувь, хүнсний ногооны 27 хувийг өөрсдөө хангадаг болов. Улаанхус, Цэнгэл, Сагсай сумдад 7 услалтын системийг шинээр барьж, Өлгий сумын услалтын системийг сэргээн засварласнаар аймгийн усалгаатай талбайн хэмжээ 4300 га-д хүрэв.

**2007-2010 ОНУУДАД АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН УСЛАЛТЫН СИСТЕМ**




**11. Ахмадуудаа баярлуулав**

Өлгий суманд Ахмадын ордон, Толбо суманд ахмад настны сувилал нөхөн сэргээлтийн танхим барьж, Зоостод 10 ор бүхий ахмадын амралтын тасаг буй болгож ахмадуудаа баярлуулав



**12. Төсвийн орлого нэмэгдэж, ирэдийн хадгаламж өсөв**

Сүүлийн хоёр жилд аймаг төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 40,0-17,1 хувиар буюу 993,7-493,8 сая өгрөгөөр давуулан биелүүлж санхүүгийн чадавхи нь дээшлэв. 2011 оны 4-р сарын 1-ний байдлаар аймгийн нийт хүн амын 44,6 хувь нь буюу 39,8 мянган хүн банкинд нийт дүнгээрээ 28,1 тэрбум өгрөгийн хадгаламжтай байгаа нь иргэдийн амьжиргааны түвшин ахиж байгааг харуулна.



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР**